СХЗГ-ын 2018.09.06-ны А/286-р хүчингүй болсон

# СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

# ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 27

"Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай" Монгол Улсын хуулийн 20.2.3, Засгийн Газрын 2010 оны 119 дүгээр тогтоол, "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ын 1.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн тогтолцоо - үндсэн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дүрэм баталсантай холбогдуулан Стандартчилал, Хэмжил зүйн Үндэсний зөвлөлийн 2003 оны 59 дүгээр тогтоол "Дүрэм батлах тухай журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Шийдвэрийг Хууль, Зүй Дотоод Хэргийн Яаманд хянуулж, бүртгүүлэх ажлыг Стандартчилал, хэмжил зүйн газрын Стратегийн удирдлага, төрийн захиргааны хэлтсийн дарга /О.Отгонсайхан/-д даалгасугай.

Дөрөв. Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Стандартчилал, хэмжил зүйн газрын Итгэмжлэлийн хэлтсийн дарга /М.Мөнгөнбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЭНХТАЙВАН

Улсын бүртгэлд 2011 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 3259 дүгээрт бүртгэсэн.